



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар A/109

Батноров сум

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны А/275 тоот тушаал, Аймгийн мал эмнэлгийн 2024 оны 08 дугаар сарын 05-ны А/46 тоот тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны 08 сарын 06-ны А/408-н тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд сумын хэмжээний бүх хонийг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 05-аас 20 хоногийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг “Дэлгэрэхсүрэг” ХХК-ий захирал малын эмч А.Мөнхбаяр, “Бөмбөг шарга” ХХК-ий захирал малын эмч (Б.Баясгалан) “Мааньт хөхий” ХХК-ий захирал малын эмч (Ш.Эрдэнэчимэг), “Энхсүрэг вет” ХХК-ний захирал малын эмч (Г.Өсөхбаяр), “Ажнай вит” ХХК-ний малын эмч (Н.Мөнхтуяа), Хувирахуй ХХК-ний захирал малын эмч М.Алтанчимэг нарт үүрэг болгосугай.

2. Дархлаажуулалтын маршрут зураглал гаргах, хамрагдах өрхийн судалгааг гаргаж, тарилга хийх хашаа хоолойг бэлтгэн, мал сүргээ бэлэн байлгах ажлыг урьдчилан мэдэгдэж, зохион байгуулалт хийж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид мал бүхий иргэд заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д, хариуцуулсугай.

4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох газарт цаг хугацаанд нь

4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох газарт цаг хугацаанд нь мэдээ, мэдээллийг хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б. Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР